



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 10 сарын 08 өдөр

Дугаар А/188

Улаанбаатар хот

Нийслэлийн хүүхдийн 248 дугаар цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.7, 4.8 дугаар хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны А/126 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 08 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 17,778,770.00 (арван долоон сая долоон зуун далан найман мянга долоон зуун дал) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Нийслэлийн хүүхдийн 248 дугаар цэцэрлэг (Ж.Энхзул)-т зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй 1 нэр төрлийн 811,000.00 (найман зуун арван нэгэн мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгах, 9 нэр төрлийн 16,967,770.00 (арван зургаан сая есөн зуун жаран долоон мянга долоон зуун дал) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт хүлээлгэн өгөхийг Нийслэлийн хүүхдийн 248 дугаар цэцэрлэг (Ж.Энхзул)-т, татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА *В.Оюумаа* В.ОЮУМАА



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 0 дугаар сарын 01 -ны өдрийн 18 дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн хүүхдийн 248 дугаар цэцэрлэг

д/д	Хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Бүгд үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	Байгууллагын үнийн санал	НӨХГ-ийн мэргэжлийн дүгнэлт	УХХХ-ийн шийдвэр
1	Компьютер /ширээний/	7	ш	2	1,403,820.00	2,807,640.00	2,807,640.00		Эвдэрсэн		-	татах	татах
2	Даралтад хөгжим	7	ш	1	1,247,000.00	1,247,000.00	1,247,000.00		Эвдэрсэн		-	татах	татах
3	Асег-13 laptop	5	ш	1	1,150,000.00	1,150,000.00	1,150,000.00		Эвдэрсэн		-	татах	татах
4	Асег-15 laptop	5	ш	1	1,500,000.00	1,500,000.00	1,500,000.00		Эвдэрсэн	актлах саналтай	-	татах	татах
5	Дэлгэц 32 инч	3	ш	2	500,000.00	1,000,000.00	1,000,000.00		Эвдэрсэн		-	татах	татах
6	Принтер олон үйлдэлтэй	5	ш	1	385,770.00	385,770.00	385,770.00		Эвдэрсэн		-	татах	татах
7	Принтер /сапон/	5	ш	1	217,360.00	217,360.00	217,360.00		Эвдэрсэн		-	татах	татах
8	Жин 0.3i	5	ш	1	110,000.00	110,000.00	110,000.00		Эвдэрсэн		-	татах	татах
Тоног төхөөрөмжийн дүн				10	6,513,950.00	8,417,770.00	8,417,770.00						
1	Хүүхэд хүлээн авах зөврийн сууц	5	ш	1	8,550,000.00	8,550,000.00	8,550,000.00	-	Эвдэрсэн	актлах саналтай	-	татах	татах
Бусад үндсэн хөрөнгийн дүн				1	8,550,000.00	8,550,000.00	8,550,000.00						
1	Санхүүгийн програми	4	ш	1	811,000.00	811,000.00	811,000.00		ашиглахгүй	актлах саналтай	-	устгах	устгах
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн				14	811,000.00	17,778,770.00	811,000.00						
					Үүнээс. Худалдах хөрөнгө								
					Устгах хөрөнгө								
					Татан төвлөрүүлэх хөрөнгө								
					Худалдсанаас олох орлого								
					НӨХГ-т төвлөрүүлэх /30%/								